

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	6
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	6
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.12. Шилэн дансны мэдээлэл	7
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	7
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	7
3. Менежментийн захидал	8
3.1. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал	8
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	9
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	9
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	10
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	11
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	12
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ
ХАМГААЛАХ, УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ НЬ
II ТӨСЛИЙН ҮНДЭСНИЙ ЗАХИРАЛ
Б.ОЮУНСАНАА ТАНАА

2020.03.09 № 06/754
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нь II төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нь II төслийн оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нь II төслийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл, тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нь II төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нь II төслийн үндэсний захирал Б.Оюунсанаа Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагналыг үнэн зөв, оновчтой болгож санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэр гаргалтад шаардлагатай мэдээллийг зохистой болгох зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нь II төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нь II төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 2 дугаар сарын 20-наас 2020 оны 2 дугаар сарын 28-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 2 дугаар сарын 28-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын захиалгаар “Интер аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нь II төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 05/2020 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд

аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нь II төслийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь Монгол орны тусгай хамгаалалттай газар нутгийн болон нийлмэл/холбоос нутгуудын (орчны бүс болон экологийн коридор, кластер) тогтвортой, үр дүнтэй менежментийг бэхжүүлэх, биологийн олон янз байдлыг хамгаалах, орчны бүс дэх орон нутгийн ард иргэдийн тогтвортой амьжиргааг дэмжихэд оршино.

Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нь II төслийн дараах 4 бүрэлдэхүүн хэсэгтэй. Үүнд:

Зорилт 1: Менежментийн төлөвлөгөө болон тусгай хамгаалалттай газруудын сүлжээний хөрөнгө оруулалт хийх;

Зорилт 2: 4 том бүс нутаг (кластер)-ийн менежментийн болон бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх;

Зорилт 3: Урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн үндсэн дээр сонгогдсон 7 хүртэлх бие даасан тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн болон бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх;

Зорилт 4: тусгай хамгаалалттай газар нутгийг сүлжээний хэмжээнд чадавхижуулах, олон нийтэд таниулах арга хэмжээ явуулах.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нь II төслийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нь II төсөл нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Интерактив Би Ай” ХХК-ийн “Emerald” программ хангамж ашигладаг байна.

Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нь II төсөл нь дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт нь үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нь II төслийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 3 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөлтийн үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг бага гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 52,323.9 мянган төгрөгөөс тооцон 523.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинд өөрчлөлт ороогүй. Учир нь төлөвлөлтийн үе шатанд тодорхойлсон эрсдэлтэй дансуудад горим хэрэгжүүлэхэд материаллаг байдлын түвшинг өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нь II төсөл нь 2019 оны 6 дугаар сараас хэрэгжиж эхэлсэн тул өмнөх тайлант оны санхүүгийн дүн мэдээ гэж байхгүй.

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс болон Монгол Улсын Засгийн Газраас санхүүжилт авах гэрээтэй боловч тайлант онд зөвхөн Монгол Улсын Засгийн газраас санхүүжилт авч үйл ажиллагаа явуулсан.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 2,606.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд тавилга, эд хогшил болон програм хангамжийг худалдан авч өмч хөрөнгийг нэмэгдүүлснээс шалтгаалжээ.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь 246,300.0 мянган төгрөгийн төсвийг урсгал зардалд зарцуулахаар батлуулжээ.

Нийт зардал болох 246,300.0 мянган төгрөгийг улсын төсвөөс 100 хувь санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 49,717.8 мянган төгрөг буюу 20.1 хувьтай байгаа нь тайлант үед 5 хүнийг төсөл хэрэгжүүлэгч нэгжид үндсэн орон тоогоор ажиллуулахаар төлөвлөсөн боловч төслийн эхлэх хугацаа хойшилсны улмаас 2 орон тоотой ажилласнаас шалтгаалсан. 2019 оны 6 дугаар сар хүртэл 152,000.0 мянган төгрөгийн санхүүжилт авснаас 52,323.9 мянган төгрөгийг он дуустал үйл ажиллагаандаа зарцуулахаар дахин төлөвлөж, үлдсэн мөнгийг буцаан татуулсан.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 3 эрсдэлд зориулж гүйцэтгэлийн үе шатанд 3 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийг арилгаж ажиллах 1 зөвлөмж өглөө.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Тайлант онд хийгдсэн аудитын ажилд үндэслэн шилэн дансанд мэдээллийг цаг тухайд нь үнэн зөв оруулж буй эсэхийг анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нь II төсөл нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан толилуулах ёстой 89 мэдээллээс 49 мэдээллийг хугацаанд нь, 40 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нь II төсөл нь 2019 оны 05 дугаар сараас үйл ажиллагаа явуулж эхэлсэн тул өмнөх онд санхүүгийн тайлангийн аудит хийгдээгүй. Тиймээс ямар нэг зөвлөмж, албан шаардлага, төлбөрийн акт байхгүй.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нь II төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нь II төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал

3.1.1. Илрүүлэлт:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан толилуулах ёстой 89 мэдээллээс 40 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

3.1.2. Эрсдэл:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг хугацаанд нь толилуулахгүй, улмаар энэ хуулийн 10 дугаар зүйлийн дагуу энэ хуулийг зөрчсөн албан тушаалтан Төрийн албаны тухай хуулийн дагуу хариуцлага хүлээх.

3.1.3. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн дагуу бүх мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд цаг хугацаанд нь толилуулж байх.

3.1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудиторын өгсөн зөвлөмжийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу биелүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	-	-
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	-	-
35400	Хангамжийн материал	-	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	-	2,606,073.83
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	-	2,606,073.83
39203	Авто-тээврийн хэрэгсэл	-	-
39204	Хуримтлагдсан элэгдэл	-	-
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	-	-
39206	Хуримтлагдсан элэгдэл	-	-
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	-	347,985.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-	(7,390.00)
39301	Програм хангамж	-	2,392,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(127,021.17)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	-	2,606,073.83
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	2,606,073.83
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	-	2,606,073.83
51	Засгийн газрын хувь оролцоо	-	2,606,073.83
51200	Хуримтлагдсан үр дүн	-	2,606,073.83
51210	Өмнөх үеийн үр дүн	-	-
51220	Тайлант үеийн үр дүн	-	2,606,073.83
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	-	2,606,073.83

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	-	52,323,900.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	-
122	ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	-	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	52,323,900.00
131	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	52,323,900.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	-	52,323,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	49,717,826.17
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	49,717,826.17
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	49,717,826.17
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	-	0.00
210102	Нэмэгдэл цалин	-	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	228,882.00
210201	Тэтгэврийн даатгал	-	
210202	Тэтгэмжийн даатгал	-	
210203	ҮОМШ өвчний даатгал	-	
210204	Ажилгүйдлын даатгал	-	
210205	Эрүүл мэндийн даатгал	-	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	43,870,696.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	43,870,696.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	134,411.17
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал	-	134,411.17
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	228,882.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	228,882.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	-	2,606,073.83
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	-
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	-	2,606,073.83

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	-	
131001	Улсын төсвөөс Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	52,323,900.00
120009	Бусад мөнгөн орлого	-	70,000.00
	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	-	52,393,900.00
2	Нийт зарлага ба зээлийн дүн	-	
21	Урсгал зардал	-	
210101	Цалин	-	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	
210201	Тэтгэврийн даатгал	-	3,729,037.00
210202	Тэтгэмжийн даатгал	-	438,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	351,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	-	87,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	-	877,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад ажил үйлч төлбөр хураамж	-	43,870,696.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	228,882.00
210818	Бусад мөнгөн зарлага	-	70,000.00
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	-	49,653,415.00
	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	-	2,740,485.00
	Хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээ	-	
	Хөрөнгө оруулалтын мөнгөн орлогын дүн	-	-
5	Хөрөнгө оруулалтын мөнгөн зарлага	-	
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардал	-	2,740,485.00
	Хөрөнгө оруулалтын мөнгөн зарлагын дүн	-	2,740,485.00
	Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ	-	(2,740,485.00)
25	Санхүүгийн цэвэр мөнгөн гүйлгээ	-	
	Санхүүгийн цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
100	Тохируулгын орлого зарлагын зөрүү	-	-
2	Нийт зарлага ба зээлийн дүн	-	
21	Урсгал зардал	-	

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	-	-	-
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн нэмэгдэл	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн бууралт	-	-	-	-
2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	-	-	-
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	2,606,073.83	2,606,073.83
Үндсэн хөрөнгийн нэмэгдэл	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн бууралт	-	-	-	-
2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	-	2,606,073.83	2,606,073.83

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
УРСГАЛ ЗАРДАЛ	52,323,900.00	52,095,018.00	228,882.00	99.6
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	52,323,900.00	52,095,018.00	228,882.00	99.6
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,703,200.00	5,483,837.00	219,363.00	96.1
Тэтгэврийн даатгал	3,948,400.00	3,729,037.00	219,363.00	94.4
Тэтгэмжийн даатгал	438,700.00	438,700.00	0.00	100
ҮОМШӨ-ний даатгал	351,000.00	351,000.00	0.00	100
Ажилгүйдлийн даатгал	87,700.00	87,700.00	0.00	100
Эрүүл мэндийн даатгал	877,400.00	877,400.00	0.00	100
Эд хогшил, урсгал засварын нэр	2,750,000.00	2,740,485.00	9,515.00	99.6
Багаж, техник, хэрэгсэл	2,400,000.00	2,392,500.00	7,500.00	99.7
Тавилга	350,000.00	347,985.00	2,015.00	99.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	43,870,700.00	43,870,696.00	4.00	100
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	43,870,700.00	43,870,696.00	4.00	100
Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	0.00	0.00	0.0
Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	0.00	0.00	0.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	0.00	0.00	0.0
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	0.00	0.00	0.00	0.0
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	0.00	0.00	0.0
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	0.00	0.00	0.00	0.0
Улсын төвлөрсөн төсвөөс	0.00	0.00	0.00	0.0
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	0.00	0.00	0.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.0
Төсвийн бусад мэдээллийн ангилал				
Ажиллагсдын тоо	5	2	-3	40
Удирдах ажилтан	0	0	0	0
Гүйцэтгэх ажилтан	5	2	-3	40
Үйлчлэх ажилтан	0	0	0	0
Гэрээт ажилтан	0	0	0	0

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2020.02.28	Аудитын нэр:	2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан	Аудитын код:	САГ-2020/46/СТА-ТХН
Шалгагдсан байгууллагын нэр:	Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нь II төсөл			Мянган төгрөгөөр	

Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
		Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5
Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан шилэн дансны зарчим болон 6 дугаар зүйлд заасан шилэн дансны мэдээллийг цаг хугацаанд нь байршуулдаггүй байна.	-	Зөвлөмж	Санхүүгийн ажилтан	Д.Пүрэвсүрэн
Нийт дүн	-			

